

## ОЛОН УДААГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ВИЗ (С-3-3)

### ОЛГОХ ХҮРЭЭ :

БНСУ-ын эрүүл мэндийн байгууллагуудад эмчлүүлэн эдгэрэх зорилгоор тус улсад олон удаа нэвтрэх шаардлагатай хүн.

Анх удаа тус визийг мэдүүлж буй иргэн “Виза файндерт”заасны дагуу материалаа бүрдүүлэх.

Олон удаагийн эмчилгээний визтэй хүмүүсийн хувьд БНСУ-д эмчлүүлж байсан нотлох баримтуудаа сайтар бэлдэх.

**\* Тус визээр зорчигчид нь хөдөлмөр эрхлэх боломжгүй болно.**

- 3-н жилийн олон удаагийн виз: 1 жилийн олон удаагийн виз авч байсан, визний хугацаандаа 2 ба түүнээс дээш зорчсон, оршин суух хугацаандаа аливаа зөрчил гаргаж байгаагүй иргэн
- 5-н жилийн олон удаагийн виз: 3 жилийн олон удаагийн виз авч тухайн хугацаанд аливаа зөрчил гаргаж байгаагүй иргэн мөн байнга зорчдог иргэн

**\* 3 ба 5 жилийн олон удаагийн визийг тухайн визний хүчинтэй хугацаагаа дуусахаас 1 сарын өмнө мэдүүлэх боломжтой. (жишээ нь: 2022.01.31 өдөр визний хугацаа нь дуусах бол 2022.01.01 өдрөөс визээ мэдүүлэх боломжтой)**

Энэхүү ангиллын визээр Монгол Улсаас БНСУ-д зорчихыг хүсэж буй иргэн бүр Солонгосын Виз Мэдүүлгийн Төвөөр дамжуулан виз мэдүүлнэ. Та 1, 3 болон 5 жилийн 30 хоногийн хугацаатай олон удаагийн виз мэдүүлэх боломжтой.

БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримт шаардах боломжтой. Виз мэдүүлгийн бичиг баримтууд нь эх хувь эсхүл хуулбар байна.

### Дараах нөхцөлүүдээс өөрт тохирохыг сонгож, материалаа бүрдүүлнэ үү

#### БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Эмнэлгийн урилга (эх хувь),  
Цаг захиалгын бичиг (эх хувь),  
Тухайн эмнэлгийн аж ахуй нэгжийн гэрчилгээний хуулбар,  
Гадаад өвчтөн хүлээж авах эрх бүхий байгууллагын гэрчилгээ

2. Виз мэдүүлгийн маягт, Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг

3. Гадаад паспорт/ Хуулбар 1 хувь

4. Гэрлэлтийн лавлагаа (Сүүлийн 45 хоногийн дотор олгосон байх)

5. ЭСЯ-наас заасан Монгол эмнэлгийн гэрчилгээ/ албан бичиг.

**\* Тус гэрчилгээ нь тухайн өвчтөнийг 30-с дээш хоног эмчилгээ хийлгэх шаардлагатай гэдгийг тусгасан байх.**

ЭСЯ-наас заасан Монгол эмнэлэг: Гэмтэл согог судлалын үндэсний төв, Хавдар судлалын үндэсний төв, Улсын 1, 2, 3-р төв эмнэлэг, Интермед эмнэлэг, Грандмед эмнэлэг, УБ Сонгодо эмнэлэг

**6. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт**

- **Аж ахуйн нэгжийн захирал:** Байгууллагын татварын тодорхойлолт (нэг улиралд төлсөн татварын хэмжээ 400,000 төгрөгөөс дээш байх, аж ахуйн нэгжийн захирлаар томилогдон 6 сараас дээш ажилласан байх)
- **Байгууллагын ажилтан:** Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт(сүүлийн 6 сарын турш нийгмийн даатгалын дэвтэр дээр бичигдсэн сар бүрийн үндсэн цалин 1 сая төгрөгөөс дээш байх)
- **Бусад:** Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга(хамтран эзэмшигч байх боломжгүй) (2019.09.16-аас хэрэгжинэ)

\* Банкны хуулгыг хураангуйгаар өгөх.

\* Дээрх санхүүгийн чадвар нотлох бичиг баримт нь БНСУ-д эмчлүүлэх болон оршин суух бүх зардал төлөх чадварыг нотолж байх